



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 5/15

Өмнөдэлгэр сум

Ажил хавсруулан гүйцэтгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 56.1, 56.2, 109.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын нярав Э.Цэвэг 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн архив бичиг хэргийн ажилтан томилогдох хүртэлх хугацаанд архив, бичиг хэргийн ажилтны албан үүргийг хавсруулан гүйцэтгүүлсүгэй.

2. Э.Цэвэгт цалин хөлсний хэмжээ, албан тушаалын тодорхойлолтыг танилцуулахыг нийгмийн бодлогын мэргэжилтэн (Т.Эрдэнэтуяа)-д даалгасугай.

3. Э.Цэвэгт ажил хавсарсны нэмэгдлийг үндсэн цалингийн 40 хувиар нэмж тооцож олгохыг нягтлан бодогч (Б.Гантулга)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Л.БАЯРМАА

